

7

“ШИНЭ ЭДИЙН ЗАСАГ”

Б.Бат

Сүүлийн үед эдийн засагчдын анхаарлыг татаж байгаа асуудлын нэг бол “Economy of information technology”, “Digital economy”, мөн “New economy” хэмээн янз бүрээр нэрлэгдэж байгаа эдийн засгийн шинэ урсгал юм. Өнөөдөр өндөр хөгжилтэй орнууд болон зарим хөгжиж буй орнуудын хувьд мэдээллийн технологийн хөгжил, хувьсал өөрчлөлтүүд маш хурдацтай явагдаж, энэхүү хөгжил дэвшил нь эдгээр орнуудын хүн амын өдөр тутмын хэрэглээ болсоор байна.

Өнөөдөр дэлхий дахинд глобальчлалын асуудал маш өргөн хүрээтэй болж байна. Миний бие глобальчлалын эсрэг үзэл баримтлалдаг хэдий ч манай орон мэдээллийн технологийн салбарыг түлхүү хөгжүүлэхийн тулд глобальчлалд зайлшгүй хамрагдах ёстой гэж үздэг. Хэрвээ мэдээллийн технологийг үр ашигтай ашиглаж чадвал газрын доорх баялгаа (аль хэдийн хоцрогдож хог дээр хаях болсон техник төхөөрөмжийг ашиглан олборлохын зэрэгцээ байгаль орчноо бохирдуулж байгаа) гадаадынханд хямд үнээр худалдан түүхий эдийн хавсарга орон болох, (мэдээллийн хомсдолоос болж) өндөр хөгжилтэй орнуудын зах зээлээс аль хэдийн шахагдаж гарсан хуучин техник технологийг худалдан авах, ажиллах хүчний дутагдал нэрээр гадаадын үй олон цагаач ажилчдыг авч дотоодын ажилчдаа ажлын байргүй болгон ядуурлыг “импорт”-лох замаар глобальчлагдаж буй зэргээс хавьгүй илүү үр дүнг манай орны эдийн засагт авчрах болно хэмээн бодож байна. Дээрх глобальчлалын сөрөг нөлөөллүүдийг мэдээллийн технологийн нэвтрэлт болон глобальчлалын үндсэн асуудлыг зүй зохистой шийдвэрлэх замаар бууруулах боломжтой юм.

Энэхүү мэдээллийн технологи түүний дотроос интернет болон компьютерийн салбарт гарч байгаа техникийн дэвшил эдийн засгийн өсөлт, дэвшил, хөгжилтөнд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалсан эдийн засагчид нь энэхүү “шинэ эдийн засаг” гэсэн нэр томъёог тодорхойлж гаргаж ирсэн юм. Тэд эдийн засгийн өсөлт, дэвшил хөгжил дэх мэдээллийн технологийн үүрэг, ач холбогдлыг өндрөөр үнэлж хэрэгжүүлэх нь бидний мэдэх уламжлалт эдийн засгийн суурь онолуудыг өөрчилж болох юм гэж тодорхойлж байна. Нөгөө талаар үүнийг шүүмжлэгч эдийн засагчид байгаа ба тэд мэдээллийн технологийн эдийн засаг дахь нөлөөг бусад хүчин зүйлсийн нөлөөллөөс доогуур үзэж байна. Ингээд та бүхэнд “Шинэ эдийн засаг” гэж чухам юу болох талаар Америкийн “Эдийн засагч” сэтгүүл дээр гарсан материалаас товчлон сийрүүлж, толилуулж байна.

Мэдээллийн технологи гэдэг нь өөртөө компьютер, хэрэглээний программууд, телеком мөн

интернетийг агуулж байгаа юм. Мэдээллийн технологи бол бидний хоорондоо харилцах харилцааны, өдөр тутмын ажлын, эд зүйлс худалдан авалтын, тэр ч байтугай тоглоом тоглох хэрэгсэл гээд олон зүйлээр илэрч байдаг гэдгийг мэдэх билээ. Гэвч эдгээр нь үнэхээр эдийн засагт бодит өөрчлөлтийг авчирч байна уу? гэсэн асуултыг тавих хэрэгтэй.

Үүнийг хүлээн зөвшөөрөгч эдийн засагчид: мэдээллийн технологи нь эдийн засгийн түргэн өсөлтөнд дэмжлэг үзүүлж, улмаар инфляци болон эдийн засгийн мөчлөгийн аль алиныг нь арилгаж байна хэмээн баталж байна. Харин үүнийг үл хүлээн зөвшөөрөгчид: онлайннар имэйл явуулах, текст файл болон зураг татаж авах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нь сайхан л хэрэг, харин интернэт нь хэзээ ч хэвлэх төхөөрөмж, моторт хөдөлгүүр, цахилгаан эрчим хүчтэй адилтгах үр дагаврыг авчрахгүй гэж үзэж байна.

Хэнийх нь үг үнэн бэ? Энэ талаар бодит судалгаанууд олон хийгдсэн ба үр дүн нь дээрх хоёр үзэл баримтлалын тэг дундуур гарч ирсэн гэж хэлж болно.

Калифорнийн Их Сургуулийн эдийн засагч Брэд Дэлон “Мэдээллийн технологи болон Интернэт нь Аж үйлдвэрийн хувьсгалын үеийн технологи биеийн хүчийг асар ихээр нэмэгдүүлсэнтэй адил оюун ухааны хүчийг мөн тийм хэмжээгээр нэмэгдүүлж байна” гэжээ. Гэвч мэдээллийн технологи (цаашид МТ гэх) үнэхээр урьд өмнө хийгдсэн технологийн дэвшлүүдтэй зүйрлэх үр дагаврыг авчирч байна уу? гэсэн асуултанд хариу авахын тулд дараах хэдэн тестийг хийж үзэх хэрэгтэй байж болох юм.

Нэгдүгээрт: МТ нь бидний өдөр тутмын амьдралыг хэрхэн яаж өөрчилж байна вэ? Төмөр зам, телеграф болон цахилгаан нь Интернэтийг бодвол маш их эрс өөрчлөлтүүдийг авчирсныг бид мэдэх билээ. Жишээлбэл, цахилгаан гэрэл нь ажлын өдрийг уртасгасан, төмөр зам нь ачаа тээвэр болон хүмүүсийг маш богино хугацаанд урт замыг туулах боломж олгосон гэх мэт. Ер нь шинжлэх ухааны томоохон ололтууд нь эдийн засгийн үр ашгийг зайлшгүй их хэмжээгээр авчирдаггүй. Тухайлбал, хэвлэх төхөөрөмжийг авч үзвэл энэ нь өнгөрсөн зууны хамгийн том ололтуудын нэг боловч нэг хүнд ногдох бүтээгдэхүүний өсөлтөнд бага хэмжээний нөлөөллийг үзүүлсэн юм. Шинжлэх ухааны үүднээс авч үзвэл Интернэт нь хэвлэх төхөөрөмж, телеграф, цахилгааныг бодвол төдийлөн том ололт биш байж болох хэдий ч эдийн засагт авчрах нөлөөллийн хувьд эдгээрээс илүү байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Үүний нэг шалтгаан бол зардлын тухай асуудал байгаа ба харилцаа холбооны зардлын хувьд өмнө хийгдсэн технологиудыг бодвол харилцаа холбооны хэрэгслийн зардлууд хэд дахин хямд байгаа нь эдийн засаг нийгэмд тэдгээрийг өргөн, гүнзгий хэрэглэх боломжийг олгож байна. Харин цахилгаан телеграф гэх мэтийн хувьд өртөг зардал нь одоо болтол өндөр хэвээр байгаа бөгөөд эдийн засагт өргөнөөр нэвтрэх боломж нь хязгаарлагдмал хэвээр байна.

Хоёрдугаарт: МТ нь үйлдвэр эрхлэгчдийн хувьд өөрсдийн үйлдвэрлэлийн процесс болон бизнесээ зохион байгуулах болон илүү үр ашигтай болоход нь нөлөөлөх бөгөөд ямар нөлөө байна гэдгийг анхаарч үзэх шаардлагатай. Цахилгаан болон төмөр зам үйлдвэрлэгчдэд хэрэглэгчийн асар том зах зээлийг хялбар олоход тусалсан нь хэн бүхэнд ойлгомжтой. Харин одоо компьютер болон интернэт нь бизнесийг дахин цоо шинээр байгуулах, өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг онлайннар худалдан авч үйлдвэрлэлийн гарцыг онлайннар худалдах энэхүү бизнесийн зохион байгуулалтыг санал болгож байна.

Гуравдугаарт: МТ нь нийт эдийн засгийн хөдөлмөрийн бүтээмжинд хэрхэн нөлөө үзүүлэх вэ? гэдэг асуудал юм. Бүтээмжийн хурдан өсөлт нь баталгаат амьжиргааны өндөр түвшин г хангана гэж хэлж болно. Компьютер нэвтэрснээр эдийн засаг дахь бүтээмжийн өсөлт асар ихээр хурдассан билээ. Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлтийн түвшин өндөр,

инфляцийн түвшин бага байгаагийн бас нэг шалтгааныг эдийн засагчид МТ-ийн өргөн нэвтрэлттэй холбон тайлбарлаж байна.

Иймд "Шинэ эдийн засаг" үнэхээр эдийн засгийн үндсэн хуулиудыг өөрчилж байна уу? гэсэн асуулт гарч байгаа юм. Мөнгөний болон монополийн эсрэг хууль нь төмөрлөгийн болон машины үйлдвэрлэлийн хувьд л үүргээ гүйцэтгэсэн, харин компьютер болон мэдээллийн сүлжээний эрин үед эдгээр бодлогуудын хэрэглэгдэх үүрэг роль эрс багасах болно гэсэн маргаан дэгдээсэн үзэл бодлыг зарим эдийн засагчид дэвшүүлэн тавиад байна.

Харин Карл Чапиро болон Холл Вариан гэх мэт эдийн засагчид өөрсдийн "Мэдээллийн удирдлага" номондоо: "Технологи өөрчлөгдөнө, харин эдийн засгийн хууль бол үгүй" гэж бичсэн байдаг. Эдийн засгийн мөчлөгийн зүй тогтол хараахан арилаагүй байна, инфляци өсдөгөөрөө өснө, үнийн хувь ашгийн хувиас хамаарсаар байна, иймээс засгийн газар монополийн эсрэг түүнийг арилгах бодлого үргэлжлэн хадгалагдах болно гэж тэдгээр эдийн засагчид үзэж байна.

Магадгүй бүх эдийн засгийн гол үндсэн удирдлага нь МТ байж болох ч энэ нь эдийн засгийн "өвчин"-үүдийг бүгдийг нь анагаах шидэт эм болохгүй нь ойлгомжтой.

Үндсэндээ дэлхийд шинэ ололтын 4 том давалгаа гарсан гэж хэлж болно. Нэгдүгээрт, 1780-1840 оны хооронд гарсан Английн аж үйлдвэрийн хувьсгал (түлшээр ажилладаг уурын хөдөлгүүр); хоёрдугаарт, 1840-1890 оны хооронд төмөр замын эрин; гуравдугаарт, 1890-1950 оны хооронд цахилгаан эрчим хүч болон машин үүсэж бий болсон нь эхний гурван давалгаа болно. Харин одоо бид мэдээллийн эрин зуунд амьдарч байна. Хүмүүс технологийн өөрчлөлтөөс үргэлж айж эмээж байдаг. Харин технологийн дэвшилгүйгээр дэлхий ертөнцийн айх аюул улам ихсэж болох талтай. Эдийн засаг бүхэн капитал болон хөдөлмөрийн нөөцөөр хязгаарлагдмал байдаг гэдгийг бид бүгд мэднэ. Иймээс эдгээр нөөцийг ашиглах илүү сайн арга замгүйгээр эдийн засгийн өсөлт удалгүй хөөс мэт замхран алга болох болно гэж эдийн засагчид үзэж байна.

1950-иад оноос хөгжин эхэлсэн уламжлалт эдийн засгийн өсөлтийн онол нь капитал ба хөдөлмөрийн хүчин зүйлд тулгуурласан технологийн дэвшлийг гадаад хүчин зүйл гэж үздэг загварт үндэслэж байв. Харин 1980-аад онд Паул Ромер болон бусад эдийн засагчдын үндэслэсэн шинэ онол нь технологийн дэвшлийг гол цөм хүчин зүйлээ болгосон. Энэхүү "шинэ өсөлтийн онол" нь оюун санаа мэдлэгийг зах зээлийн хариу үйлдэлд нөлөө үзүүлэх дотоод хүчин зүйл гэж тодорхойлжээ.

Ерөнхийдөө МТ нь үнийг бууруулахаас гадна анхаарал татууштай 4 шинж тэмдгийг өөртөө агуулж байна. Үүнд:

1. МТ бол маш түргэн тархах (нэвтрэх) чанартай. МТ эдийн засгийн салбаруудад дахь пүүсийн зах зээлийн загвараа зохиохоос авахуулаад бүхий л тооцоо болон пүүсийн хийж байгаа зүйлийн үр ашгийг дээшлүүлэхэд бодит нөлөөллийг үзүүлнэ. Моторт хөдөлгүүр, цахилгаан болон төмөр замын бий болгосон бүтээмжийн үр ашиг нь зөвхөн аж үйлдвэрүүд болон бүтээгдэхүүнийг хуваарилахад голлон төвлөрч гарч байсан бол МТ-ийн бүтээмжийн үр ашиг нь үйлчилгээний салбарт ялангуяа эрүүл мэнд, боловсрол, санхүү, засгийн газрын үйл ажиллагаанд илүү үр дүн авчирна гэж тооцоолж байна.

2. МТ нь мэдээллийг илүү хялбар олж авах боломжийг олгож, улмаар зах зээлийг илүү үр ашигтай ажиллах боломжийг олгоно. Хэрэглэгчид интернэтээс бараа бүтээгдэхүүний хамгийн бага үнийн талаарх мэдээллийг төвөггүй олж пүүсүүд олон захиалагчдын саналыг нэг дор авах боломжтой болно. Мөн зах зээлд нэвтрэх саад бэрхшээл болон үйл ажиллагааны зардлыг бууруулах болно. Өөрөөр хэлбэл, бидний сурах бичгээс үздэг төгс мэдээлэлтэй, үйл

ажиллагааны зардал нь 0 (пүүсүүдийн зардал тэнцүү), олон худалдан авагч, олон нийлүүлэгч гэсэн төгс өрсөлдөөнт зах зээлийн хэлбэр рүү шилжиж ойртох боломжийг олгоно гэсэн үг юм. Сайн мэдээллээр бүрэн дүүрэн хангагдсан зах зээл бол нөөцийг үр ашигтай хуваарилах үндэс суурь билээ. Хөдөө аж ахуй эрхлэгчид цаг агаарын мэдээ болон өөрийн бүтээгдэхүүнийхээ үнийг эдийн засгийн бусад бүс дэх үнэтэй харьцуулах боломжийг төвөггүй олж авна.

3. МТ нь глобальчлалын нэг суурь болно. МТ ба глобальчлал нь бие биентэйгээ маш нягт холбогдоно. Харилцаа холбооны зардлыг бууруулснаар МТ нь бүтээгдэхүүний болон капиталын зах зээлийг илүү глобальчлагдахад тусалж байна. Глобальчлал нь эргээд өрсөлдөөнийг урамшуулж худалдаа болон хөрөнгө оруулалтаар дамжин шинэ технологи нэвтрэх үүд хаалга болж өгнө.

4. МТ нь шинэ ололтыг бий болгох хурдацыг улам нэмэгдүүлнэ. Маш том хэмжээний тоон егөгдлийг хялбар, хямдаар олж авах процессыг урамшуулж, шинэ бүтээгдэхүүн зохион бүтээхэд зарцуулагдах цагийг багасгана.

Харин "шинэ эдийн засаг"-ийн онолчдын үзэл баримтлалыг шүүмжлэгчид: "МТ нь хөдөлмөрийн бүтээмжинд дорвитой өөрчлөлт оруулаагүй, харин монополийн хялбар үүсэх боломжийг нэмэгдүүлнэ, мөн цалингийн ялгаа болон ядуурлыг улам нэмэгдүүлнэ" хэмээн үзэж байна.

"Шинэ эдийн засаг"-ийн онолоор эдийн засгийн хөгжил урагшлах тусам мэдлэгт тулгуурлан хөгжих болно хэмээн үзэж байна. Ямар нэг зүйлийг хамгийн сайн аргаар хийхийг хайсаар ирсэн нь үргэлж урт хугацааны өсөлтийн эх үүсвэр болдог гэжээ.

Мөн "Шинэ эдийн засаг"-ийн "шинэ" гэдэг үгийн утгыг авч үзвэл, орчин үеийн эдийн засаг дахь үйлдвэрлэлийн өсөлт нь материаллаг зүйлийг бодвол "нүдэнд үзэгдэж, гарт баригдашгүй" оюун санаан дээр тулгуурлаж бий болно гэсэн санааг илэрхийлж байгаа юм. Иймээс ийм эдийн засгийг "жингүй эдийн засаг" гэж ч бас нэрлэж болно гэж үзэж байна. 1900 оны эхээр Америкийн нийт хөдөлмөр эрхлэгчдийн 1/3 нь үйлчилгээний салбарт ажиллаж байсан бол өнөө үед 3/4-аас илүү нь энэ салбарт ажиллаж байна.

Эдийн засагчдад "мэдлэг болон оюун санаа" нь хомсдолын талаарх эдийн засгийн үндсэн хуулийг зөрчиж байгаа мэт харагдаж байгаа учраас онолын тодорхой асуудалтай (проблем) учраад байгаа юм. Тухайлбал, биет бүтээгдэхүүн хүрзийг жишээ болгон авбал хүрзийг эзэмшиж байгаа хүн түүнийгээ худалдвал дахин түүнийг эзэмшихгүй, өөрөөр хэлбэл, хүрээ эзэмших эрх нь худалдан авагчид шилжинэ гэсэн үг юм. Харин "оюун санаа"-ны хувьд эзэмшигч хүн нь түүнийгээ хэд дахин худалдсан ч эзэмших эрхээ хадгалсаар үлдэх болно. Компьютерийн хэрэглээний программууд болон Интернэтийн бүтээгдэхүүнүүд яг энэ зарчим дээр суурилж хийгдсэн байдаг билээ. Тиймээс хэдий хэмжээгээр хэрэглэсэн ч дуусна гэсэн ойлголт байхгүй гэсэн үг. Иймд 200 жилийн тэртээ Адам Смитийн тодорхойлсон зах зээлийн систем нь хомсдолын (үзэл бодол) ойлголтонд суурилж байсан ба зардлын бүтцийн хувьд аливаа зүйлийг нэгээс илүү үйлдвэрлэхэд зардал нь нэмэгдэнэ гэсэн онолтой зөрчилдөж байгаа юм.

Уламжлалт эдийн засгийн онолоор нэгж бүтээгдэхүүнийг нэмж үйлдвэрлэх нэгжийн зардал өсдөг учраас ихэнх аж үйлдвэрүүд "буурч буй өргөжилтийн өгөөж" рүү явдаг ба нэг ч пүүс зах зээл дээр удаан хугацаагаар оршин тогтнож чадахгүй (ноёрхож чадахгүй) хэмээн үздэг. Харин мэдээллийн бүтээгдэхүүний хувьд тоо хэмжээ өссөн ч тухайлбал, хэрэглээний программууд, ном, кино, санхүүгийн үйлчилгээ болон интернэтийн вэб сайтууд нь "өргөжилтийн өсөж буй үр өгөөж"-тэй байдаг. Мэдээлэл бол анх үйлдвэрлэхэд их зардал гарч, харин дахин үйлдвэрлэхэд хямд өртөгтэй болно. Өндөр тогтмол зардал, өчүүхэн хэмжээний хувьсах зардал нь тухайн пүүсийг эдийн засгийн өргөн хэмжээтэй (эдийн засгийн хэмжээ нь томрох) болоход хүргэж болохыг үгүйсгэхгүй.